



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2019 оны 12 сарын 20 өдөр

Дугаар A/186

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь заалт, Байгууллагын дотоод журмын 7 дугаар зүйлийн 7.1.4, 7.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нутгийн удирдлагын ордны үйлчилгээний албан хаагчдын ажлын үр дүн, хариуцлага идэвхийг үнэлэн 2.250.000 төгрөг/ Хоёр сая хоёр зуун тавин мянган /-өөр, Байгууллагын аварга ажилчдад тус бүр 350.000 мянган төгрөг, Цэргийн штабын дарга хурандаа Б.Ганхуяг, Цахилгаанчин Улсын хошой мэргэн Ц.Батзориг нарт тус бүр 300.000 мянган төгрөг, албан хаагчдын нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг оношилгооны зардалд 720,000 мянган төгрөг нийт 4.390.000 төгрөг /дөрвөн сая гурван зуун ерөн мянган/-ийн урамшууллыг тус тус олгосугай.

2. Урамшуулал олгох албан хаагчдын нэрсийг хавсралтаар баталсугай.

3. Албан хаагч нарт олгох 4.390.000 төгрөг / Дөрвөн сая гурван зуун ерөн мянга /-ийн урамшууллыг хэмнэгдсэн зардлаас олгохыг Санхүү, аж ахуйн тасгийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч /Б.Нямдэлгэр/-д даалгасугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД